



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/173

Чингис хот

Худалдан авах ажиллагаа зохион  
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын хуучин сургуулийн барилгыг засварлаж хүүхэд хөгжлийн төв, ахуйн үйлчилгээний төв байгуулах, Чингис хотын хатуу хучилттай авто замын засвар, арчлалт, хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийх ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	О.Сэдэд	Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга / Ц.Дэмбэрэлсайхан /-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА